

## 7 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хугацаа-60 минут

**А ХУВИЛБАР**

Нийт-20 оноо

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

### **Жирх**

Гэнэт миний ард өвс шажигнах чимээ гарлаа. Эргээд харвал бяцхан жирх ерхөгний толгой тас татан өмөр өмөр идэж суух аж. Жирх самрын чинээ буурцгийг урд 2 хөлөөрөө хавчаад шар шархийтэл хазалж өмөр өмөр иднэ. Буурцагны цаанаас ам нь үл харагдана. Мөн ч жижигхэн амтай амьтан юм даа. Ийм амьтан энэ их хүж ой тайга бүрхсэн ерхгийг хэчнээн удаан идээд юухан хороох вэ. Би жирхийг үргээхээс болгоомжлон бараг зүрхээ чагнаж суулаа.

Хэн ч зүрхэлж цочоомооргүй эгдүүтэй хөөрхөн амьтан бол энэ жирх юм байна. Ийм амгалан амьтантай зүүний сүвэгч үзэгдэх ойрхон ингэж тааралдана гэдэг аз гэж би баярлаж өдөржин энд суусан ч яахав гэж бодов.

Жирхийг үгээр зурна гэвэл яг олон дүрслэхэд бэрх юм. Мойл шиг хар мөртлөө оч шиг гялалзсан нүдтэй юм. Нарны туяанд очин хар нүд нь хааяа гялс гялсхийн цавчирна. Буурцаг хавчсан хоёр хөл нь богинохон мөртлөө овоо бахим, үлгэрлэвээс мариатай хүүхдийн чигчий хуруу гэмээр өхөөрдөм. Зурамных шиг эрээн урт сүүл нь шарласан навч дунд сагсалзана. Хэл мэддэгсэн бол уулын толгойд цасанд дарагдсаныг чи харж байна уу? Хүнсээ базаасан биз гэж түүнээс асуумаар байлаа.

Гэвч жирх намайг ганцхан дуугарвал л үргээд талийна байлгүй. Би сүүдрээ ч хөдөлгөхгүйг хичээж мөрөө хавчсан хэвээр суув. Жирх хэдэн буурцаг идээд нааш цааш гүйлээ. Тэгснээ бас нэг идэх юм олоод авлаа. Тэр нь түлээчний орхисон шинэ цавчис. Жирх цавчисны өчүүхэн өөдөс олж зуугаад бас л тар тархийтэл хэмэлж гарав.

Энэ үед пад падхийсэн чимээ гарч дэргэдэх хушнаас хэдэн боргоцой жирхний хажууд уналаа. Тэгмэгц жирх час час дуугараад цавчсаа зуусан хэвээрээ боргоцойноос бултах мэт гялалзан дэгдсээр ширэнгэ сүлжин алга болов. Жирхнээс юунд чи ингэж дэмий айв даа. Ажилсгаараа ой даяар цуутай сааралхан хэрэм л чамд боргоцой унагаж өгсөн шүү дээ.

1. Эхээс дуурайх үг 2-ыг олж бичээрэй. \2 оноо\

.....

2. “Жирх час час дуугарав. Боргоцойноос зугтав.” гэсэн энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгон найруулаарай. \2 оноо\

.....

3. “Би сүүдрээ ч хөдөлгөхгүйг хичээж мөрөө хавчсан.” Өгүүлбэр юугаар холбогдсоныг тодорхойлж, өөр бүтээврээр солин найруулж бичээрэй. \2оноо\

.....

4. Тоочсон эх болохыг жишээгээр батлаарай. \2 оноо \

.....

5. Шарласан- зөв бичих дүрмийг тайлбарлаарай. \2оноо \

.....

6. “Алагдай аварга” найраглалыг уншаад төрсөн мэдрэмж сэтгэгдлээ 40-50 үгэнд багтаан бичээрэй. \5 оноо\

.....

.....

.....

.....

.....

.....

7. Дараах эхийг хөрвүүлж бичээрэй. \5 оноо\

تسار م ملسار حم و نام كو  
 نكمن م ملسار سمنن حم نكمنن كو  
 لاروب موشو ملسار حم مرسننسو  
 ملسار  
 نام و ملسار كمنن ملسار  
 ملسار ملسار ..

.....

.....

.....

.....

.....

.....

Анги, бүлэг.....

шифр.....

**7 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Хугацаа-60 минут

**Б ХУВИЛБАР**

Нийт-20 оноо

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Багш**

Ангийн хаалга нээгдэж Батсүх багш минь орж ирэх нь ертөнцийн хаалга нээгдэж, Бурхан багш залрах лугаа адил бөлгөө. Багш минь хичээл зааж байхад түүнээс гэрэл цацрах мэт байдаг сан. Түүний цээл сайхан хоолой тасалгаа дүүрэн цуурайтаж, бид түүний чин зүрхний үг, дуу хоолойн аялга, хөдөлгөөн бүхэнд олзлогдож, түүнтэй өнгөрүүлсэн агшин бүр энэ ертөнцөөс бидэнд заяасан нэгэн их бэлэг, хайр хишиг болдог байлаа. Түүнийг ярьж байхад бид ширүүхэн амьсгалахаас ч айдаг байлаа. Тэр бол ер бусын агшин юм. Түүнийг гарч одоход биднээс ямар нэгэн юм тасран салах шиг болоод гунигтай, түүнийг орж ирэхэд нэг ангийн гучин хэдэн хүүхэд түүнтэй нэгдэж, нэгэн амь, нэгэн бие, нэгэн санаа болон хувирах бөлгөө. Жинхэнэ багш гэгч ийм буюу. Өнөө ч бид ямар нэгэн муу юм хийхдээ Батсүх багш минь дуулчих вий гэж эмээх бөгөөд сайн юм хийхдээ ганц тэр минь л сонсоосой гэж хүсэх бөлгөө.

Багш дуулна, багш уйлна. Шавь нарынх нь зүрхэнд ардын дууны гэгээн аялгуу, давтагдашгүй угс цутган орно. Өндөр гэгээн Занабазар Ногоон дарь эх бүтээсэн шиг Содномдаш багш маань "Шавь нараа урлан туурвина." "Тэднийхээ сэтгэлийг бүтээнэ"... Сайн эр, сайхан хүн болох гэсэн хүсэлд эзэмдүүлнэ. Яахин муу юм хийнэ. Багш өөрөө дуу зохионо. Багш өөрөө аяыг нь хийнэ. Бид гайхна. Содномдаш багш шигээ болохсон гэж хүснэ. Өндөр туранхай, гуниглангуй, цагаан царайтай тэр хүн ард түмнийхээ үлдээсэн өв, яруу тансаг ая дууг цуглуулна. Цуглуулсан, ойлгосноо хүүхдүүд шавь нартайгаа хуваалцана. Ардын дуугаар хүмүүжсэн, аавын хүүхдүүд өсөж торнино. Арван зүгтээ нисэн одно.

1. Зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. \2 оноо\  
.....  
.....
2. “Содномдаш багш хичээл заана. Хүүхдүүд чагнан сууна.” гэсэн энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгон найруулаарай. \2 оноо\  
.....  
.....
3. “Ертөнцийн хаалга нээгдэж, Бурхан багш залрах лугаа адил бөлгөө” гэсэн өгүүлбэр юугаар холбогдсоныг тодорхойлж, өөр бүтээврээр солин найруулж бичээрэй. \2оноо\  
.....  
.....  
.....
4. Тоочсон эх болохыг жишээгээр батлаарай. \2 оноо \  
.....  
.....  
.....
5. амьсгалахаас - зөв бичих дүрмийг тайлбарлаарай. \2оноо \  
.....  
.....
6. “Алагдай аварга” найраглалыг уншаад төрсөн мэдрэмж сэтгэгдлээ 40-50 үгэнд багтаан бичээрэй. \5 оноо\  
.....  
.....  
.....  
.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Дараах эхийг хөрвүүлж бичээрэй. \5 оноо\

1. Өдөр бүр хичээл хийж  
 үргэлжлүүлж байх  
 нь зөв үү. Үгүй бол  
 ямар үр дагавартай  
 байх вэ?

.....

.....

.....

.....

.....

.....